



ИРГЭДИЙН АРИЛЖААНЫ ЭСКРОУ ДАНСНЫ ГЭРЭЭ

НЭГ. ГЭРЭЭНИЙ АГУУЛГА

- 1.1. Энэхүү гэрээг нэг талаас ХААН Банк (цаашид Төлбөр гүйцэтгэх банк буюу ТТБ гэх), нөгөө талаас “БИДИСЕК ҮЦК”ХК (цаашид ҮЦК гэх), ҮЦК-ийн харилцагч нар байгуулав.
- 1.2. Энэхүү гэрээгээр ХААН Банк нь ҮЦК болон ҮЦК-ийн харилцагчид, үнэт цаасны арилжааны төлбөр тооцоог гүйцэтгүүлэх тусгайлан данс нээж, харилцагчийн мөнгөн хөрөнгийг тодорхой бус хугацаагаар байршуулах, ҮЦК-иас ирүүлсэн үнэт цаасны төлбөр тооцоог гүйцэтгэх, бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн бэлэн бус зарлагын гүйлгээ хийх, Банкны хүү, шимтгэл хураамжийн ерөнхий нөхцөлд заасны дагуу шимтгэл, үйлчилгээний хөлсийг төлөх, талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.3. Талууд энэ гэрээг Монгол Улсын Иргэний хууль, Банкны тухай хууль, Банк болон эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны хууль, үнэт цаасны арилжааны төлбөр тооцоог зохицуулахаар гаргасан ҮЦТТХТ болон ХААН Банкны холбогдох журам, банк болон ҮЦК хооронд байгуулсан гэрээ, ХААН Банкнаас ҮЦК-ийн харилцагчид зориулсан арилжааны эскроу дансны нөхцөл, Бүтээгдэхүүн, үйлчилгээний шимтгэл, хураамжийн ерөнхий нөхцөлд үндэслэн байгуулж байна.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ҮНДСЭН НӨХЦӨЛ

2.1	ХААН Банкны салбар/тооцооны төв:	
2.2	Данс эзэмшигчийн овог, нэр:	
2.3	Регистрийн дугаар:	
2.4	Оршин суух хаяг:	
2.5	Хамтран эзэмшигчийн нэр:	
2.6	Арилжааны эскроу дансны дугаар:	
2.7	Мөнгөн тэмдэгт:	
2.8	Дансанд заавал байлгах доод үлдэгдэл:	
2.9	Гэрээ хүчин төгөлдөр болох огноо:	

- 2.10 Данс эзэмшигч гэж ҮЦК-ийн харилцагч буюу дээрх хүснэгтэл заасан этгээдийг ойлгоно. ХААН Банкнаас ҮЦК-ийн харилцагчид зориулсан арилжааны эскроу дансны нөхцөл, Бүтээгдэхүүн үйлчилгээний шимтгэл, хураамжийн ерөнхий нөхцөлтэй тус тус танилцсан байх ба талууд гэрээний бүхий л нөхцөлийг зөвшөөрсөн байна.
- 2.11 Харилцагч нь үнэт цаас худалдсан бол түүнээс олох мөнгөн орлогыг арилжааны эскроу дансаар хүлээн авна.
- 2.12 Харилцагч нь эскроу данснаас зарлагын гүйлгээ гаргах хүсэлтээ ҮЦК-д гаргана. ҮЦК хүсэлтийг хянаад биржийн хэлцлийн төлбөрийн өргүй тохиолдолд хүсэлтийг баталгаажуулан, харилцагчийн зарлагын гүйлгээ гаргах хүсэлтийн хамт ТТБ-д шилжүүлнэ.
- 2.13 Харилцагчийн хувьд данс нээхэд тавигдах шаардлага нь ХААН Банкны Харилцагч бүртгэх бодлого журам, Депозит бүтээгдэхүүний бодлого журам болон Үнэт цаасны арилжааны төлбөр тооцооны түр журмын дагуу байна.
- 2.14 Данс эзэмшигч нь өөрийн худалдан авсан үнэт цаасны төлбөрийг гүйцэтгэх болон банкинд хийгдэх гүйлгээний хураамжийг суутгахад хүрэлцэхүйц мөнгөн хөрөнгийг арилжаа хийгдэхийн өмнө арилжааны дундын дансанд 100 хувь байршуулсан байна.
- 2.15 ҮЦТТХТ нь харилцагч өөрөө хүсэлт гаргасан, шүүх, СЗХ болон бусад эрх бүхий байгууллагын шийдвэрээр харилцагчийн дансны гүйлгээг түр зогсоох ба хаана.

ГУРАВ. ДАНС ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1. Дансны гүйлгээ, үлдэгдлийг дансны хуулгатай тулган шалгах, дансандаа үнэт цаас худалдан авах төлбөрийг бүрэн байршуулах;
- 3.2. Банк гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс учирсан хохирлыг арилгуулахаар эрх бүхий байгууллагад хандах, шүүхэд нэхэмжлэл гаргах;
- 3.3. Харилцагч нь арилжаа хийсэн өдрөөс хойш арилжааны нийт дүнг банкинд дахь данснаасаа арилжааны төлбөр хийх өдөр банк арилжааны гүйлгээ болон шимтгэлийн гүйлгээг суутгаж автал зарлагын гүйлгээ хийхгүй байх;
- 3.4. Харилцагч нь энэхүү гэрээний 2.6-д заасан дансыг үнэт цаасны арилжааны төлбөр тооцоо гүйцэтгэхээс бусад зориулалтаар ашиглахгүй байх;
- 3.5. Харилцагчийг төлөөлөх эрх бүхий этгээдийг томилсон хууль ёсны итгэмжлэлийг банкинд хүргүүлэх, өөрчлөлтийг мэдэгдэх;
- 3.6. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг зөрчихгүй байх;
- 3.7. Хууль тогтоомж болон ҮЦТТХТ-ийн “Үнэт цаасны төлбөр тооцоог Т+1 горимоор гүйцэтгэх түр журам”-д заасан бусад эрх үүрэг;

ДӨРӨВ. ҮЦК-ИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 4.1. ҮЦК нь харилцагчийн арилжааны төлбөр тооцоо гүйцэтгэх мөнгөн хөрөнгийг арилжааны төлбөр хийх өдөр арилжааны эскроу данс банкинд нээж байршуулсан тохиолдолд захиалгыг биелүүлэх;
- 4.2. ҮЦК нь харилцагчаас ирүүлсэн эскроу данснаас зарлагын гүйлгээ хийх хүсэлтийг хянаж биржийн хэлцлийн төлбөрийн өргүй тохиолдолд хүсэлтийг баталгаажуулан, харилцагчийн зарлагын гүйлгээ гаргах хүсэлтийн хамт ТТБ-д илгээх;
- 4.3. Харилцагчийн эскроу дансанд хийгдсэн гүйлгээ, үлдэгдэлийн файлийг тухай бүр шалгах, системд нэвтрэн харах эрхтэй байх;
- 4.4. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг зөрчихгүй байх;
- 4.5. Хууль тогтоомж болон ҮЦТТХТ-ийн “Үнэт цаасны төлбөр тооцоог Т+1 горимоор гүйцэтгэх түр журам”-д заасан бусад эрх үүрэг;
- 4.6.

ТАВ. БАНКНЫ ЭРХ, ҮҮРЭГ

- 5.1. ҮЦТТХТ-д албан хүсэлт гаргаж харилцагчийн данстай холбоотой мэдээллийг авах;
- 5.2. Төлбөрийн үүргээ биелүүлээгүйтэй холбоотой аливаа асуудлаар ҮЦТТХТ-д хүсэлт гаргах;
- 5.3. Гэрээ байгуулах үедээ өөрийн үйл ажиллагаатай холбогдсон үнэн зөв мэдээллийг өгөх;
- 5.4. Төлбөр тооцоо гүйцэтгэх банкинд тавигдах шалгуур болон банкны заавал байлгах хөрөнгө, санхүүгийн нөөцийн доод хэмжээг хангах;
- 5.5. Өөрийн буруугаас данс эзэмшигчид учруулсан хохирлыг нөхөн төлөх;
- 5.6. ҮЦК-аас хүрэлцэн ирэн төлбөрийн хүсэлтийг үндэслэн харилцагчийн арилжааны эскроу данснаас ҮЦК-ийн төлбөр тооцооны дансанд төлбөрийг бүрэн төвлөрүүлэх;
- 5.7. Данс эзэмшигч болон түүний данстай холбоотой мэдээллийг чандлан нууцалж, хуульд зааснаас бусад тохиолдолд бусад задруулахгүй, өөр зорилгоор ашиглахгүй байх;
- 5.8. Данс эзэмшигч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс учирсан хохирлыг арилгуулах;
- 5.9. Хууль тогтоомж болон ҮЦТТХТ-ийн “Үнэт цаасны төлбөр тооцоог Т+1 горимоор гүйцэтгэх түр журам”-д заасан бусад эрх үүрэг;

ЗУРГАА. БУСАД

- 6.1. Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээний бүхий л нөхцөлийг хүлээн зөвшөөрсөнд тооцно.
- 6.2. Энэхүү гэрээний хугацаа нь ТГБ, ҮЦК нарын хооронд байгуулсан Үнэт цаасны арилжааны төлбөр тооцоо гүйцэтгэх түр гэрээний хугацаа дуусгавар болсноор дуусгавар болно.
- 6.3. Энэ гэрээ нь Монгол хэл дээр 3 хувь үйлдэгдсэн бөгөөд эх хувиуд адил хүчинтэй байна. Гэрээний албан ёсны орчуулгад ойлгомжгүй зөрүүтэй зүйл гарсан, маргаан үүссэн тохиолдолд Монгол хэл дээрх хувилбарыг баримтлана.
- 6.4. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд түүнийг гагцхүү бичгээр үйлдэж, талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлт нь үндсэн гэрээний салшгүй хэсэг байна.
- 6.5. Гэрээг аль нэг тал хүсэлт гаргасан буюу талууд харилцан тохиролцсон, эсхүл талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зөрчсөний улмаас гэрээний бусад талд хохирол учрах бодитой нөхцөл үүссэн буюу бодит хохирол учруулсан болон хуульд заасан бусад үндэслэлээр цуцална. Гэрээ цуцлахаас өмнө өр төлбөрийн үүргийг бүрэн биелүүлсэн байна.
- 6.6. Энэ гэрээгээр зохицуулаагүй бусад харилцааг үнэт цаасны арилжааны төлбөр тооцоог зохицуулахаар гаргасан ҮЦТТХТ-н холбогдох журам болон гэрээгээр зохицуулна.
- 6.7. Гэрээг хэрэгжүүлэх явцад гарах аливаа маргааныг талууд эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд эс бөгөөс Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 6.8. Төлбөр тооцооны баримтын бүрдүүлбэр дутуу, үлдэгдлээ бүрэн байршуулаагүй г.м шалтгааны улмаас төлбөр саатан гүйлгээ хийгдэх боломжгүй болсон тохиолдолд үүсэх хариуцлагыг банк хүлээхгүй.

Энэ гэрээний нөхцлүүдтэй танилцаж, харилцах/хугацаагүй хадгаламжийн данс нээхийг зөвшөөрч байна.

Гэрээ байгуулсан данс эзэмшигч (ид):

Нэр/ Баталгаат гарын үсэг _____ / _____ / **Огноо** _____

Хаяг: _____

Утас: _____

Гэрээг байгуулсан ҮЦК-ийн ажилтан:

Нэр/Гарын үсэг _____ / _____ /

Албан тушаал _____ **Огноо** _____

Хаяг: _____

Утас: _____

Данс нээх гэрээг байгуулсан банкны ажилтан:

Нэр/Гарын үсэг _____ / _____ /

Албан тушаал _____ **Огноо** _____

Хаяг: _____

Утас: _____